



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022.01.03 № А-6/08
танай _____-ны № _____-т

**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ
ЭМНЭЛЭГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай
731 дүгээр тогтоолыг хүргүүлж байна.

Тогтоолын хэрэгжилтийг ханган, биелэлтийг
заасан хугацаанд ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт.....хуудастай.

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

132006676



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 731

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 143,079,000.0 (Нэг зуун дөчин гурван сая далан есөн мянган) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирал Б.Хишигжаргалд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2.Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулж, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

2.3.Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгууллагын эзэмшил газар дээр хийгдсэн гадна зам талбайн тохижилтын ажил болон өргөх зориулалттай давхар зогсоолын хөрөнгийг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авах;

2.4.Газар эзэмших эрхийн маргаантай асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газар эзэмших эрхийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж, зориулалтын дагуу ашиглах;

2.5.Эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн төрийн өмчийн газар дээр авто зогсоолын үйл ажиллагаа эрхлэх түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, түрээсийн гэрээ байгуулж орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлж ажиллах;

2.6.Төрийн өөрийн өмчийн түрээсийн 2021 оны нийт орлогын 40 хувь болох 142,223,187.0 (нэг зуун дөчин хоёр сая хоёр зуун хорин гурван мянга нэг зуун наян долоон) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.7.Гэрэгэ киоскын талбай болон диализийн аппаратыг түрээслэх түрээсийн төлбөрийг тогтоож, гэрээ байгуулах арга хэмжээ авч төрийн өөрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах;

2.8.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг хангалтгүй зохион байгуулсан байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн даргад хариуцлага тооцож, төрийн өмчийн хадгалалт хамгаалалт, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

132007184

2.9.Элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнээ нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн зөвшөөрөл авч үндсэн хөрөнгөд тусгах;

2.10.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 4 дугаар сарын 31-ны өдрийн
4 дугаар тогтоолын хавсралт

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан төсвийн зардлын эдийн засгийн ангилал, зориулалтыг зөрчиж зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	88.8	Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 41.2.2, 41.2.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.2	Төсвийн гүйцэтгэлийн үед зардлын хяналтыг хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлага анхаарч ажиллах, урсгал шинжтэй зардлаас хөрөнгө бэлтгэхдээ зөвшөөрөл авах
2	Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хийгдсэн нийтийн эзэмшлийн байгууламжийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй.	-	Сангийн сайдын 2014 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.5	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хүсэлт хүргүүлж хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэх ажлыг зохион байгуулах
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээсийн гэрээгүй ашиглуулсан	2.1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоол	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол болон холбогдон гарсан журмыг мөрдөх
4	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, биетээр байхгүй хөрөнгө	52.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71 дүгээр хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын	Хөрөнгө оруулалтаар шинэчлэгдсэн нийтийн эзэмшлийн байгууламжийн хөрөнгийг акталж данснаас хасуулах арга хэмжээ авах
НИЙТ ДҮН:		143.079 (нэг зуун дөчин гурван сая далан есөн мянга)		

**“УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ”-ИЙН ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД
ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ,
ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу “Улсын нэгдүгээр төв эмнэлэг”-ийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Э.Ганчимэг, мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ө.Батбаатар нар 2021 оны 11 дүгээр сарын 18-ний өдрөөс эхлэн 2021 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг дуустал ажлын 7 хоногт хяналт шалгалт хийлээ.

Шалгалтыг удирдамжид заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн болон бусад анхан шатны баримтад үндэслэн явууллаа.

Шалгалтад хамрагдах хугацааны санхүүгийн баримтад гарын үсэг зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан албан тушаалтны мэдээллийг харуулбал:

Нэгдүгээр гарын үсэг зурсан албан тушаалтан				
Д/д	Овог нэр	Албан тушаал	Эхэлсэн огноо	Дууссан огноо
1	Т.Мөнхсайхан	Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2019.07.05	2020.07.08
2	Н.Лхажий	Ерөнхий захирал	2020.08.18	2021.07.22
Хоёрдугаар гарын үсэг зурсан албан тушаалтан				
1	Б.Банзрагч	Ерөнхий нягтлан бодогч	2019.09.30	Одоог хүртэл

Хяналт шалгалтыг хэрэгжүүлж байх үед 2020.12.29-ний өдөр томилогдсон Б.Хишигжаргал эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байлаа.

Санхүүгийн тооцоололдоо VERITECH програмыг ашиглаж байна. Үндэсний аудитын газар нь тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 1925 оны 10-р сарын 25-ны өдөр буюу 96 жилийн тэртээ “Ардын эмнэлэг” нэртэйгээр европ эмнэлгийн 8, лам ёсны түвд эмнэлгийн 7, нийт 15 ортой эмнэлгийг 1 орос, 3 монгол эмчтэйгээр анхны сууриа тавьж байжээ.

Ардын эмнэлгийг 1935 оноос Клиникийн эмнэлэг болгон өргөжүүлсэн ба 1971 онд Чехословак улсын тусламжаар баригдсан 24656 м2 талбай бүхий 240 ортой, эмнэлгийн байртай болсон бөгөөд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 150-р тогтоол, Эрүүл мэндийн яамны сайдын 278 дугаар тушаалаар Нэгдсэн 1-р эмнэлгийг Улсын Клиникийн Төв Эмнэлэг болгосон бол Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 231 тоот тогтоолоор Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг болгон өөрчилжээ.

2015 онд дахин 6542 м2 талбай бүхий эмнэлгийн зориулалтын өргөтгөлийн байрыг ашиглалтанд оруулж одоо нийт 568 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

УНТЭ нь амбулаторын болон хэвтүүлэн эмчлэх чиглэлээр өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг 21 аймаг, УБ хотын 9 дүүргийн иргэдэд үзүүлдэг.

2020 оны жилийн эцсийн байдлаар 495 ортой, амбулаторын тусламж үйлчилгээг 331440 хүнд, оношилгоо шинжилгээ 450302 хүнд, 3079095 сеанс, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг 21842 хүнд, мэс заслын тусламж үйлчилгээг 13288 хүнд, дотрын тусламж үйлчилгээг 8554 хүнд, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг 20284 хүнд, эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээг 854 хүнд, гемодиализийн тусламж үйлчилгээг 129 хүнд 15156 сеанс, элэг шилжүүлэн суулгах хагалгааг 23 хүнд, бөөр шилжүүлэн суулгах хагалгааг 29 хүнд, ясны чөмөг шилжүүлэн суулгах эмчилгээг 7 хүнд, дунгийн суулгацын хагалгааг 15 хүнд тус тус хийсэн байна. Тус эмнэлэг нийт 840 ажилтантай үүнээс:

- Удирдах албан тушаалтан 13
- Эмч 205
- Сувилагч, тусгай мэргэжилтэн 377
- Захиргаа дэмжих үйлчилгээний ажилтан 245

Монгол Улсын Засгийн газраас 2017 онд батлагдсан Монгол Улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яам, Сангийн яамтай хамтарч Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах техник туслалцааны 9701 МОН төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

УНТЭ нь 2020 оны дөрөвдүгээр сараас эхлэн хагас бие даасан байдалд шилжин ажиллаж эхэлсэн бөгөөд 2021 оны гуравдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн гүйцэтгэлээрээ санхүүждэг даатгалын шинэ журмаар ажиллаж байна.

ГУРАВ. ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛТ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эргэлтийн бус хөрөнгийн талаар:

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь балансын дүнгээр нийт эргэлтийн бус хөрөнгийн 2019 оны байдлаар 66,994.1 сая төгрөг буюу 98.6 хувийг биет хөрөнгө, 919.6 сая төгрөг буюу 1.4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байсан бол 2020 оны байдлаар 76,386.6 сая төгрөг буюу 98.8 хувийг биет хөрөнгө, 954.6 сая төгрөг буюу 1.2 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл	2019.12.31 /сая.төг/			2020.12.31 /сая.төг/			
		Балансын үнэ	Элэгдэл хорогдуулалт	Дансны цэвэр дүн	Балансын үнэ 2020/12/31	Элэгдэл хорогдуулалт 2020/12/31	Дансны цэвэр дүн	Хувийн жин /цэвэр дүн/
1	Биет хөрөнгө	66,994.1	28,505.5	38,488.6	76,386.6	32,940.5	43,446.1	98.8%
2	Биет бус хөрөнгө	919.6	55.32	864.3	954.6	245.1	709.5	1.2%
Нийт дүн		67,913.7	28,560.8	39,352.9	77,282.5	33,185.6	44,096.9	100%

Нийт эргэлтийн бус хөрөнгийн балансын дүн 2019 оны байдлаар 67,913.7 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 28,560.8 сая төгрөг, дансны цэвэр дүн 39,352.9 сая төгрөг байсан бол 2020 оны байдлаар 77,282.5 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 33,185.6 сая төгрөг, дансны цэвэр дүн 44,096.9 сая төгрөг болж өссөн дүнтэй байна.

3.1. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, түүний эрх зүйн үндэслэл

Улсын 1 дүгээр төв эмнэлгийн санхүүгийн тайланд туссан үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Эргэлтийн бус хөрөнгийн ангилал	2020.01.01 /сая.төг/	Өөрчлөлт /сая.төг/		2020.12.31 /сая.төг/	
	Балансын дүн	Нэмэгдсэн	Хасагдсан	Балансын дүн	Хувийн жин
Барилга, байгууламж	23,257.70	2,039.90	-	25,297.60	32.73%
Автотээврийн хэрэгсэл	204.4	-	-	204.4	0.26%
Тоног төхөөрөмж	42,194.80	7,932.10	618.8	49,508.10	64.06%
Тавилга эд хогшил	989.2	92.2	47.8	1,033.60	1.34%
Номын фонд	63.8	-	63.8	-	0.00%
Бусад үндсэн хөрөнгө	284.2	-	-	284.2	0.37%
Программ хангамж	89.2	35	-	124.2	0.16%
Бусад биет бус хөрөнгө	830.4	-	-	830.4	1.07%
Балансын нийт дүн	67,913.70	10,099.20	730.4	77,282.50	100%
Хуримтлагдсан элэгдэл	28,560.80	5,295.30	670.5	33,185.60	43%
Дансны нийт цэвэр дүн	39,352.90	-	-	44,096.90	

Тус эмнэлэг нь 2020 оны жилийн эхэнд 67,913.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлант хугацаанд 10,099.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 730.4 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж нийт 77,282.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Дансны цэвэр дүн оны эхэнд 39,352.9 сая төгрөг байсан бол оны эцэст 44,096.9 сая төгрөг болж 4,744.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар балансын нийт дүнгийн 32.73 хувийг барилга байгууламж, 0.26 хувийг тээврийн хэрэгсэл, 64.06 хувийг машин тоног төхөөрөмж, 1.34 хувийг тавилга эд хогшил, 0.37 хувийг бусад үндсэн хөрөнгө, 0.16 хувийг програм хангамж, 1.07 хувийг бусад биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Барилга байгууламжийн хувьд 1971 онд ашиглалтад орж хуучирсан байсныг 2020 онд нэлээд хэсэгт нь засвар хийж ашиглалтыг сайжруулж, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлсэн арга хэмжээ авч ажиллажээ.

Нэмэгдсэн үндсэн хөрөнгө түүний эрх зүйн үндэслэл: Улсын 1 дүгээр төв эмнэлэг нь 2020 онд Эрүүл мэндийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтаар, өөрийн санхүүжилтээр болон бусад байгууллагын хандив тусламжаар нийт 10,099.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь өмнөх онуудад байгаагүй өндөр үзүүлэлт болсон байна.

2020 оны тайлант хугацаанд нэмэгдсэн хөрөнгийн дүнг задлан харуулбал:

- Урсгал төсвийн санхүүжилтээр 2,677.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан. Нэмэгдсэн хөрөнгийг задалж харуулбал:
 - Эмнэлгийн барилгын их засварын 880,9 сая төгрөгийн, 18 нэр төрлийн хөрөнгийг барилга байгууламж дээр капиталжуулсан;
 - Эмнэлгийн зориулалтай 120 нэр төрлийн 1,669.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдаж авсан;
 - 92,235.00 сая төгрөгийн 217 нэр төрлийн тавилга эд хогшил худалдаж авсан.
 - 35.0 сая төгрөгийн 2 нэр төрлийн програм хангамжийг өөрийн урсгал санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авч орлого авч данс бүртгэлд тусгажээ.
- Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 6,986.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд 947.4 сая төгрөг нь барилга байгууламж, 6039.2 сая төгрөг нь тоног төхөөрөмж дансанд бүртгэгдсэн байна.
- Хандив тусламж буюу үнэ төлбөргүй 434.8 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн бөгөөд 211.6 сая төгрөг нь барилга байгууламж дансанд, 223.3 сая төгрөг нь машин тоног төхөөрөмж дансанд тус тус бүртгэгдсэн байна.

Улсын 1 дүгээр төв эмнэлгийн 2020 оны тайлант хугацаанд урсгал төсвийн санхүүжилтээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн эх үүсвэрийг авч үзвэл:

Дансны ангилал	Худалдаж авсан хөрөнгийн	
	Дүн /төгрөг/	тоо ширхэг
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	1,400,000	1
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	8,872,000	32
Багаж хэрэгсэл	1,634,239,942	153
Бараа үйлчилгээний бусад зардал	61,351,600	4
Тавилга	71,773,390	143
Урсгал засвар	900,138,714	21
Нийт дүн	2,677,775,646	354

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас 1.4 сая төгрөгийн 1 ширхэг яаралтай тусламжийн тэрэг, Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 8.9 сая төгрөгөөр 30 ширхэг ширээ, 2 ширхэг өлгүүр, урсгал зардлын ангиллаас 19.1 сая төгрөгийн 4 ширхэг тоног төхөөрөмж, 2 ширхэг тавилга эд хогшил, бараа үйлчилгээний бусад зардлаас 24.4 сая төгрөгийн 2 ширхэг тоног төхөөрөмж, 35,0 сая төгрөгийн 2 ширхэг програм хангамжийг нийт 43 ширхэг 88,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй худалдан авсан байна.

Хасагдсан үндсэн хөрөнгө түүний эрх зүйн үндэслэл: Төрийн өмчийн бодолго, Зохицуулалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 295 тоот тогтоолоор цаашид ашиглах боломжгүй болсон 421 нэр төрлийн 671.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгө, 2020 оны 5-р сарын 4-ний өдрийн А-1/791 тоот албан бичгээр 63.8 сая төгрөгийн номын фондыг үндсэн хөрөнгийн данснаас хасаж бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэж нийт 730.4 сая төгрөг хасагдсан байна. Энэхүү шийдвэрийг үндэслэн Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Ерөнхий Захирлын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/249 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан актлах хөрөнгийг данснаас хасах ажлыг зохион байгуулж данс бүртгэлээс хассан байна.

Холбогдох шийдвэрийн дагуу акталсан хөрөнгийг устгах, худалдан борлуулах зэрэг арга хэмжээ авч байгууллагын агуулах, гадна талбайг чөлөөлөх шаардлагатай.

3.3. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцсон байдал

Хөрөнгийн элэгдлийн зардлыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад заасны дагуу шулуун шугамын аргаар байгуулсан байна. Элэгдлийн зардлын задаргааг харуулбал:

Хөрөнгийн ангилал	Хуримтлагдсан элэгдэл /сая.төг/			
	Эхний үлдэгдэл	нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл	Хувь
Барилга, байгууламж	434.70	417.62	852.33	3%
Автотээврийн хэрэгсэл	170.24	11.51	181.75	89%
Тоног төхөөрөмж	27,320.10	4,123.97	31,444.07	64%
Тавилга эд хогшил	421.99	40.38	462.37	45%
Бусад үндсэн хөрөнгө	158.43	18.48	176.92	62%
Биет бус хөрөнгө	55.32	12.83	68.15	7%
Нийт дүн	28,560.79	4,624.79	33,185.58	75%

Нийт хөрөнгийн 75 хувь элэгдсэн байна. Нийт хуримтлагдсан элэгдлийн дүнгээр тээврийн хэрэгсэл 89 хувиар, тоног төхөөрөмж хамгийн 64.0 хувиар өндөр дүнгээр элэгдэж насжилт өндөртэй байна.

Тухайн тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтаас шалтгаалж нийт хөрөнгийн элэгдлийн сан 2020 оны эхэнд 28,560.79 сая байсан бол жилийн эцэст хамгийн ихээр буюу 4,624.79 сая төгрөгөөр өсөж 33,185.58 сая төгрөг болсон байгаа нь цаашид эх үүсвэр болох элэгдлийн зардлаар хөрөнгийн ашиглалтыг сайжруулах их засвар болон бусад хөрөнгө оруулалт хийх боломж бүрдсэн байна.

3.4. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар:

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоолын дагуу Улсын 1 дүгээр төв эмнэлэгийн эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар,

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж, үнэлгээний үр дүнг мэргэшсэн үнэлгээчин нягтлан шалгаж баталгаажуулсан бөгөөд үр дүнг санхүүгийн тайландаа тусган мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

д/д	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Бодит үнэ цэнэ,/сая.төг/
1	Эзэмших эрхтэй газар	1	830.4
2	Барилга	2	22,257.1
3	Инженерийн байгууламж	4	47.1
4	Нийтийн эзэмшлийн байгууламж	8	19.3
	Нийт дүн	15	23,153.9

Тус эмнэлэг нь СБД-ийн 1-р хороонд байрлалтай, 25645 м.кв талбай бүхий эмнэлгийн зориулалттай газар эзэмших эрхийг үнэлж 830,385,100.0 төгрөгөөр үнэлж биет бус хөрөнгийн дансанд, барилга байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламжийн нийт 14 нэр төрлийн хөрөнгийг тус тус үнэлж 22,323.4 сая төгрөгөөр биет хөрөнгийн дансанд, нийт 15 нэр төрлийн 23,153.9 сая төгрөгийн үл хөдлөх /үнэлэхгүй хөрөнгийн хамт/ хөрөнгийг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан байна.

Тус компанийн барилга байгууламжийн дахин үнэлгээг талбайн хэмжээ, нэгж өртөг, тохируулах итгэлцүүрүүд, элэгдлийн хэмжээг зөв сонгож аргачлалын дагуу үнэн зөв хийсэн тухай “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-ийн хөндлөнгийн, хараат бус мэргэшсэн үнэлгээчний тайланд дурдсан байна.

3.5. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газар эзэмших эрх, түүнтэй холбогдсон өөрчлөлт;

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг сүүлийн 15 жилийн байдлаар авч шалгалаа.

Нийслэлийн засаг даргын 2003 оны 395 дугаар захирамжаар 26400м² эзэмшил газартай байсан. Үүнээс хойш газрын хэмжээнд гарсан өөрчлөлтийг авч үзвэл:

1. Эмнэлгийн зүүн урд хэсэгт байрлалтай 450 м.кв талбай бүхий газрыг Нийслэлийн засаг даргын 2005 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 243 тоот захирамжаар хасалт хийх шийдвэр гарсан хэдий ч 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Нийслэлийн засаг даргын 474 тоот захирамжаар Мөргөл уул ХХК-д эзэмшүүлэхээр гарсан шийдвэрийн дагуу гэрчилгээнд өөрчлөлт хийгдэж УНТЭ-ийн эзэмшил газар 25950 м.кв болсон байна.

2. УНТЭ-ийн 25950 м.кв эзэмшил газраас Нийслэлийн засаг даргын 2011 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 243 тоот захирамжаар газрын кадастрын зургий 36-40 цэг болох 305м.кв талбайн газрыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шилжүүлсэн шийдвэр гарсан. 25645 м.кв болсон.

Ийнхүү УНТЭ-ийн эзэмшил 26400 м.кв талбай бүхий газраас нийтдээ 2 удаа 755 м.кв талбай хасагдаж 25645 м.кв өөрчлөгдсөн байна.

УНТЭ-ийн эзэмшиж байгаа газрын байршлын кадастрын зураг дээрх 1-2, 2-4, 69-71 цэгийг ашиглан ШШҮХ нь тэгш өнцөг хэлбэрт /эмнэлгийн өөрийн үндсэн хөрөнгөд

бүртгэлтэй дулаан, хэрэгцээний цэвэр усны шугам байрладаг/ талбайг ашиглан хашаа татаж машины зогсоолоор тус эмнэлгийн газрыг ашиглаж байна. Тус эмнэлэг ШШҮХ-ийн ашиглаж байгаа өөрийн эзэмшил газрын төлбөрөө жил бүр төлж байна. 2018 онд 2,256,760 төгрөг, 2019 онд газрын төлбөр нэмэгдэж 5,385,450 төгрөг, 2020-2021 онд 5,385,450 мянган төгрөгийг жил бүр төлж ирсэн.

3.6. Суудлын автомашины ашиглалт, техник ашиглалтын паспортын хөтлөлт

Тус эмнэлэг нь 2020 оны жилийн эхэнд 5 ширхэг 204.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгсэлтэй байсан бөгөөд тухайн жилд нэмэгдсэн хасагдсан өөрчлөлт гараагүй байна. Тээврийн хэрэгслийг газар дээр нь үзэж танилцахад “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын тээврийн хэрэгслийн мэдээлэлтэй зөрөөгүй байсан. бөгөөд нийт тээврийн хэрэгсэл нь 85 хувийн элэгдэлтэй буюу 3 нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, 63-52 УНБ Портер маркийн ачааны автомашин нь мотор цохисон, маш их муудсан байдалтай байгаа тул үр ашгийг тооцож, байгууллагын ӨХБЗ-өөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлэх шаардлагатай.

Тус эмнэлэг нь 2020 оны жилийн эцсийн байдлаар шатахуун, сэлбэг хэрэгсэл, жолоочийн цалингийн зардалд нийт 145,820. мянган төгрөгийг зарцуулсан байна. .

/мян.төг/

Гаражтай бол ашиглалтын зардал	Шатах, тослох материалын зардал	Сэлбэг бусад зардал	Жолоочийн цалингийн зардал	Татвар, даатгалын зардал	Нийт гарсан зардал
	51,599.8	9,511.3	82,587.0	2,122.6	145,820,754.2

Тээврийн хэрэгслийн паспортыг шинэчлэн хөтөлж баяжилт хийх нь зүйтэй.

3.7. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар:

Тус эмнэлэг нь 2020 онд эмийн сан, кофе шоп, хүнсний дэлгүүр, цайны газар, АТМ, массажны сандал, угаалга, сонин борлуулах цэг, СТ, хоол үйлдвэрлэл зэрэг үйлчилгээний зориулалтаар төрийн өмчийн 1003.1 м.кв талбай бүхий байр талбайг 15 хуулийн этгээдэд түрээслүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай холбогдох хууль тогтоомж, тогтоолын дагуу төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулан ажилласан байна. 2020 онд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийн сонгон шалгаруулалт зарлан шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллаж, тус онд 365.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт тухайн тайлант хугацаанд 146.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 112.1 сая төгрөг төвлөрүүлж 34.2 сая төгрөг дутуу төвлөрүүлжээ. Компани нь 2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай түрээсийн орлогоос Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогод тооцоо нийлэн баталгаажуулсан байна.

Ковидтой холбоотойгоор огт ажиллаагүй 2 түрээслэгчийн 11,12 сарын түрээсийн төлбөрийг, угаалгын газрыг гэрээгээр ажиллуулах болсонтой холбогдуулан 6 сарын түрээсийн төлбөрийг чөлөөлсөн байна.

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, хяналт шалгалтын ажлын хэсэг, эмнэлгийн санхүүгийн албаны дарга болон бусад холбогдох ажилтнуудын хамт байгууллагын хөрөнгө, түрээсийн байр талбайтай танилцсан.

Компанийн 2021 оны байдлаар бусдад түрээслүүлсэн гэрээтэй байр талбайн мэдээлэл

Түрээсийн зориулалт	Түрээслэгч байгууллагын тоо	Талбай М2	Түрээсийн төлбөр		
			төлбөл зохих	төлсөн	үлдэгдэл
Эмийн сан	5	121.45	173,629,200.00	132,974,600.00	40,654,600.00
АТМ	1	2	1,188,000.00	1,188,000.00	-
Кофе шофе	3	92.1	69,647,088.00	52,144,368.00	17,502,720.00
Хүсний дэлгүүр	1	24	21,240,000.00		21,240,000.00
Цайны газар	1	190	51,541,000.00	44,178,000.00	7,363,000.00
Эмчилгээний зориулалтаар	2	754.00	99,744,000.00	90,232,000.00	9,512,000.00
Бусад	1	6	4,356,000.00	1,452,000.00	2,904,000.00
Нийт	14	1189.55	421,345,288.00	322,168,968.00	99,176,320.00

2021 оны байдлаар эмийн сан, кофе шоп, хүсний дэлгүүр, цайны газар, АТМ, массажны сандал, СТ, хоол үйлдвэрлэл зэрэг үйлчилгээний зориулалтаар төрийн өмчийн 1189.6 м.кв байр талбайг 14 хуулийн этгээдэд түрээслүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай холбогдох хууль тогтоомж, тогтоолын дагуу төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Тус эмнэлэг нийт 421.3 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээс 2021 оны 11-р сарын байдлаар 322.2 сая төгрөг төвлөрүүлж 99.2 сая төгрөгийн түрээсийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс түрээслэгчидтэй нэг бүрчлэн уулзаж түрээсийн төлбөрийн үлдэгдэл тооцоог хийх, байр талбайд урсгал засвар хийж төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах талаар шаардлага тавьж ажилласны дүнд 94.9 сая төгрөгийн түрээсийн орлого тус эмнэлэгт төвлөрүүлсэн бөгөөд түрээсийн нийт төлбөрийн 40% хувь болох 168.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 141.4 сая төгрөгийг хяналт шалгалтын хугацаанд төвлөрүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан.

Хяналт шалгалтын явцад төвлөрүүлсэн түрээсийн төлбөрийн дүнг хүснэгтээр харуулбал:

Түрээслэгчийн нэр	Түрээсийн төлбөр	
	төвлөрүүлсэн дүн /төгрөгөөр/	гүйлгээний тоо
Ану тулга фарм ХХК	14,431,800.00	3
Бест арома ХХК	7,824,000.00	3
Гозоорой ХХК	6,091,848.00	2
Гоо Анирс фарм ХХК	300,000.00	1
Итгэлт-Анд ХХК	7,363,000.00	1
Их шүүдэргэнэ импорт ХХК	7,200,000.00	1
Мөнхийн тун мед ХХК	2,400,000.00	1
Мэжик чайр ХХК	1,452,000.00	1
Отгонбуянт хүрээ ХХК	32,760,000.00	1
Өлзийдэн ХХК	12,420,000.00	3
ХААН банк	297,000.00	2
Хийлс Эйд ХХК	2,312,000.00	1
Нийт дүн	94,851,648.00	20

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Ковид-19 цар тахал хүндэрснээр 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн УОК-ийн шийдвэрээр хатуу хөл хорио сунгагдаж тус эмнэлэг ковид-19 цар тахлаас сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд "Б" блок, эрчимт эмчилгээний хаалгыг тусгаарлан вакум хаалтаар хаасан, мөн эргэлтийн хэсгийн хаалганд хаалт хийж гаднаас орох үйлчлүүлэгчийн урсгалыг бүрэн хязгаарласан, эмийн сан, кофе шопуудаар үйлчлүүлэх иргэдийн урсгалыг хэсэгчилэн хязгаарлаж эмнэлгээр үйлчлүүлэгчдийн урсгал чиглэлд зохицуулалт хийж ажилласан бөгөөд одоог хүртэл зарим хязгаарлалтаа бүрэн нээгээгүй байна.

Мөн эмнэлэг ковид-19 туссан өвчтөн хүлээн авч зүүн байрыг улаан бүс болгон тусгаарласан, яаралтай тусламжийн хэсэгт хүлээн авах тусгаарлах өрөөг гаргах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Д/д	Түрээслэгчийн нэр	Талбай м.кв	Сарын төлбөр	1-12 сарын төлбөл зохих	Түрээсийн орлого нийт дүн	Үлдэгдэл	Хөнгөлөх боломжтой дүн	Хөнгөлөх дүнгийн 40%	Тайлбар
1	Мөнхийн тун мед ХХК /яаралтай эмийн сан/	24	2,400.0	28,800.0	12,000.0	16,800.0	14,400.0	5,760.0	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр 1-6 сар Яаралтай тусламжийн тусгаарлах хэсэг болгосон учир 6 сарын түрээсийн төлбөр хөнгөлөх
4	Отгонбуянт хүрээ ХХК /зүүн байрны эмийн сан/	36	4,680.0	56,160.0	37,440.0	18,720.0	14,040.0	5,616.0	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр Зүүн байрыг улаан бүс болгож тусгаарласан учир хөнгөлөх 3 сар
7	Мэжик чайр ХХК	6	363.0	4,356.0	1,452.0	2,904.0	1,089.0	435.6	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр 1-3 сар амбулаторийг хэсэгчилэн хаасан учир 3 сарын төлбөр хөнгөлөх
10	Ану тулга фарм ХХК /Эмийн сан-эрчимт/	17.95	4,810.6	57,727.2	52,916.6	4,810.6	4,810.6	1,924.2	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр Эрчимтийн хаалгыг бүрэн хаасан тул 1 сар хөнгөлөх
11	Хараа маркет ХХК	24	3,540.0	21,240.0	0.0	21,240.0	21,240.0	8,496.0	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр 1-6 сар Яаралтай тусламжийн тусгаарлах хэсэг болгосон учир 6 сарын түрээсийн төлбөр хөнгөлөх
12	Гозоорой ХХК /2 давхар кофе шоп/	39.5	3,045.9	36,551.1	32,088.4	4,462.7	4,462.7	1,785.1	Түрээсийн тооцоог хоногоор тооцож төлбөрийг бүрэн төлсөн, ажиллаагүй хоногийн тооцооны үлдэгдлийг чөлөөлөх

13	Бест арома ХХК /эрчимт кофе шоп/	32.6	2,608.0	31,296.0	18,256.0	13,040.0	7,824.0	3,129.6	Ковид-19 цар тахлын үед байгууллагын шийдвэрээр 1-3 сар амбулаторийг хэсэгчилэн хаасан тухайн үед зөвхөн байгууллагын ажилчдын хоол гаргаж байсан учир 3 сарын төлбөр хөнгөлөх
Нийт дүн				21,447.5	236,130.3	154,153.0	81,977.3	67,666.3	27,146.5

Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд хийгдсэн дээрх ажлуудаас болж түрээслэгч байгууллагууд хэсэгчилэн хаагдаж, зарим нь одоог хүртэл огт ажиллаагүй байна. Түрээслэгч байгууллагуудаас удаа дараа төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх тухай албан бичигүүд ирсэн бөгөөд тус эмнэлгээс цар тахлаас нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаас нь авч үзэж үлдэгдэл 154.2 сая төгрөгийн түрээсийн төлбөрөөс эмнэлэгт төвлөрүүлэх 81.9 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх 67.8 сая төгрөгийг хөнгөлүүлэх хүсэлтээ илэрхийлсэн. Засгийн газрын 2020.11.11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж дахин хэд хэдэн удаагийн шийдвэрээр хугацааг нь сунгаж ажилласан, тогтоолын хавсралтаар хязгаарлалт тогтоохгүй ажиллах төрийн байгууллага хуулийн этгээдээс бусад үйл ажиллагааг зогсоосон, мөн тухайн эмнэлэгт улаан бүс бий болгож зарим хязгаарлалтыг хийж зохион байгуулсантай холбогдуулах түрээслэгчид бүрэн ажиллаагүй тухай албан хүсэлт гаргаж иргүүлжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас короновируст цар тахлын улмаас Засгийн газрын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн хугацаанд улсын онцгой комиссын шийдвэрээр үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон түрээслэгчдийн түрээсийн төлбөрийг ямар хугацаагаар хэрхэн чөлөөлөх боломжтойг ялгавартай байдлаар хянан, дүгнэлт судалгаа гаргаж жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж, улсын төсөвт төвлөрүүлэх шаардлагатай орлогыг төвлөрүүлж ажиллахыг зөвлөж ажиллаа.

3.2.5.Өмч хамгаалах Байнгын зөвлөл, эд хөрөнгийн дотоодын тооллогын талаар

Тус эмнэлгийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-д нийцүүлэн 2019.11.08-ны өдрийн УНТЭ-ийн ерөнхий захирлын А/322 тушаалаар баталсан байна.

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах асуудлаар дүгнэлт гаргах, хагас бүтэн жилийн хөрөнгийн дотоодын тооллоготой холбогдуулан 2019 онд нийт 4 удаа хуралдаж холбогдох шийдвэр дүгнэлт гарган ажилласан байна.

Тус эмнэлгийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, чанар байдал, засвар шинэчлэлт, хөрөнгө оруулалт, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн байдал, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг асуудалд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал дурангийн

тасагт ажилладаг ходоодны 12 дурангаас 4 нь, уушигны 4 ширхэг дурангаас 1 ширхэг нь ажиллаж байгаа бөгөөд ходоод, уушиг дурандуулах эрэлт ихтэй байхад засаж сэлбээд ашиглах боломжийг бий болгох ажлыг шуурхай зохион байгуулдаггүй, мөн Ховд аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглалтгүй байгаа уушигны дуранг эрх бүхий зохих байгууллагад нь хүсэлт тавьж шилжүүлэн авч ашиглах зэрэг.

Мөн ӨХБЗ-ийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд туссан үндсэн хөрөнгийн ашиглах жил, элэгдлийн тооцоололд хяналт тавих, элэгдлийн залруулга, баркоджуулах ажил хийхээр тусгагдсан хэдий ч өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийтийн эзэмшлийн байгууламжийн хөрөнгө оруулалтаар ашиглалтгүй болж байхгүй болсон хөрөнгийг жилийн эцсийн тооллогоор байгаагаар тоолж тайлагнасан бөгөөд хөрөнгийг 2020, 2021 онд данс бүртгэлээс хасуулах асуудлыг шийдвэрлээгүй зэргээр хангалтгүй ажилласан байна.

Тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан байх бөгөөд илтгэх хуудастай танилцахад тоон үзүүлэлт талаас л зөвхөн авч үзсэн байх бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээг төрийн өмчийн ашиглалт, чанар байдал, үр ашигтай байх талаас нь харж санал дүгнэлт боловсруулж, санаачлагатай, ач холбогдол өгч ажиллах шаардлагатай байна.

“Төрийн өмч эзэмшүүлэх гэрээ”-г тухай бүр байгуулан дүгнүүлж иржээ. Гэрээний дүнгээр 2020 онд 94 хувийн үр дүнтэй үнэлэгдсэн байна.

ДӨРӨВ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

Хөрөнгийн талаар илэрсэн зөрчил дутагдал:

1.Төрийн өмчид эд хөрөнгө олж авахдаа холбогдох хууль журмыг мөрдөн ажиллаагүй байна. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2-т “Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ шаардлагаа тодорхойлж хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд газрын төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэнгийг үндэслэн Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно” гэж заасныг тус тус зөрчин урсгал шинжтэй зардлаас хөрөнгийн шинж чанартай багаж хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, их засварын зардлыг санхүүжүүлж зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд:

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үндсэн хөрөнгө олж бэлтгэхдээ батлагдсан урсгал төсвийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас 1.4 сая төгрөгийн 1 ширхэг яаралтай тусламжийн тэрэг, Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 8.9 сая төгрөгөөр 30 ширхэг ширээ, 2 ширхэг өлгүүр, урсгал зардлын ангиллаас 19.1 сая төгрөгийн 4 ширхэг тоног төхөөрөмж, 2 ширхэг тавилга эд хогшил, бараа үйлчилгээний бусад зардлаас 24.4 сая төгрөгийн 2 ширхэг тоног төхөөрөмж, 35,0 сая төгрөгийн 2

ширхэг програм хангамжийг нийт 43 ширхэг 88,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй худалдан авсан байна.

2.Нийслэлийн хөрөнгө оруулалтаар, “Жи пи экспресс финанс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 322.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтийн ажлыг 2019.12.09- ний өдрийн 3Б-08/2019 дугаартай улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтанд хүлээлгэн авч ашиглагдаж байгаа хэдий ч өнөөдрийг хүртэл НХОГ-аас ТӨБЗГ-т хандаж тус хөрөнгийг үндсэн хөрөнгөд тусгах ажил хийгдээгүй байна.

Мөн нийслэлийн хөрөнгө /нийслэлийн замын сан/ оруулалтаар, “Метахико ХХК”-ийн хийж гүйцэтгэсэн 655.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, эмнэлгийн урд талын авто машины зогсоол дээрх 16-н авто машин байрлуулах “Кар сити давхар зогсоол байгуулах төсөл арга хэмжээ”-ний хүрээнд өргөх зориулалттай авто зогсоол угсарч дууссан хэдий ч өнөөдрийг хүртэл ашиглалтгүй, эмнэлгийн үндсэн хөрөнгөд тус тус бүртгэлгүй байна.

3.Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх үндсэн хөрөнгийн үлдэгдэлд нийт 2309 нэр төрлийн 18,314.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, нийтийн эзэмшлийн байгууламж, програм нь үлдэгдэл өртөггүй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө байна.

Эдгээр хөрөнгийн ашигт ажиллагаа, чанар байдал, хэрэгцээ шаардлагаас хамаарч зарим хэсгийг акталж данснаас хасах болон цаашид ашиглах боломжтой хөрөнгөөр нь ялгаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дахь хэсэгт заасны дагуу элэгдлээрээ өртөгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн шийдвэрлүүлж дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөсөн болно.

4. Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтийн ажлыг 2019 оны 5 дугаар сард эхэлж хийх үед өмнө хийгдсэн байсан, тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 52,2 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн байгууламжийн хөрөнгө устаж үгүй болсон хэдий ч 2021 онд үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хэвээр байна.

Д/д	Хөрөнгийн нэр	ашиглалтад орсон огноо	тоо ширхэг	Нийт дүн
1	Тамхины пост	2015/09/22	1	3,252,125
2	Нийтийн зориулалттай талбай	2007/12/31	500	600,000
3	Зогссолын хаалтын автомат төхөөрөмж	2016/06/30	1	3,700,000
4	Модны суурь сав /модон/	2015/09/13	10	1,575,175
5	Асфальтан хучилтай явган хүний зам	2018/12/31	163	8,297,088
6	Бетон суурьтай төмөр хашаа	2018/12/31	50	1,664,800
7	Бут сөөг	2007/12/31	850	1,190,000
8	Бут сөөг	2012/10/01	30	45,000
9	Гэрэлтүүлэгийн шон	2018/12/31	19	1,054,272
10	Зүлэгжүүлсэн талбай	2007/12/31	438	1,007,400
11	Гацуур	2018/12/31	8	47,680

12	Мдон хашлага	2018/12/31	99	546,872
13	Сүүдрэвч	2018/12/31	1	640,000
14	Навчит мод	2007/12/31	28	33,600
15	Төмөр хашаа	2018/12/31	60	399,360
16	Төмөр хашаа	2018/05/26	1	2,600,000
17	Хайс хашлага	2007/12/31	200	2,400,000
18	Хөшөө	2015/10/02	1	500,000
19	Автомашины хатуу хучилттай зогсоол	2015/10/02	1	11,400,000
20	Хатуу хучилттай авто зогсоол	2018/12/31	120	6,680,755
21	Автомашины хатуу хучилттай зогсоол	2007/12/31	100	1,000,000
22	Шилмүүст мод	2007/12/31	5	21,000
23	Ширмэн сандал	2007/12/31	9	135,900
24	Модон сандал	2015/09/13	20	3,392,001
ДҮН			2715.1	52,183,028

Хөрөнгө оруулалтын ажил хийгдэх болсонтой холбогдуулан устах хөрөнгүүдийн жагсаалтыг гаргаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж акталж данснаас хасах санал хүргүүлж шийдвэрлүүлээгүйгээс үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хэдий ч хөрөнгө нь биетээр байхгүй байгаа зөрчил гарсан.

5.Тус эмнэлгийн тоног төхөөрөмж 64 хувь элэгдсэн мөн зарим өндөр үнэтэй багаж тоног төхөөрөмжид хийх засварын зардлыг шийдвэрлээгүйгээс тухайлбал дурангийн тасагт ажилладаг ходоодны 12 дурангаас 4 нь, уушигны 4 ширхэг дурангаас 1 ширхэг нь ажиллаж байгаа бөгөөд уушиг ходоодоо дурандуулах үйлчлүүлэгчдийн эрэлт ихтэй байхад багажийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулаагүй, эх сурвалжаас авч үзэхэд Ховд аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглалтгүй байгаа уушигны дуранг эрх бүхий зохих байгууллагад нь хүсэлт тавьж шилжүүлэн авч ашиглах зэрэгт анхаарал хандуулж, тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй.

Газар эзэмших эрхийн талаар илэрсэн зөрчил, маргаантай асуудал:

1.Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар тус эмнэлгийн эзэмшил газар дээр 2019 онд гадна талбайн тохижилтын ажил ашиглалтад оруулсны дараа уг газарт автомашины зогсоол ажиллуулах гэрээг Нийслэлийн авто замын газар, Төгс гэрэлт цамхаг ХХК-тай 2020.02.19-ний өдөр хийсэн байх бөгөөд 2021 оныг дуустал гэрээг сунган ажиллуулж байна.

Энэхүү талбайн газар эзэмших эрх тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмч бөгөөд газар ашигласны төлбөрийг эмнэлэг төлдөг. Гэтэл орон нутгийн өмчит Нийслэлийн авто замын газар уг хөрөнгийг захиран бусдад түрээслүүлж байгаа зөрчил илэрлээ. Тус эмнэлэг өөрийн хөрөнгийг бусдад ашиглуулж орлого олохгүй, зардал гаргаж ажиллаж байгаа тул гэрээ дуусгавар болж байгаатай холбогдуулан Нийслэлийн авто замын газарт өөрийн эзэмшил газар дахь авто зогсоолын үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг зарлаж, Засгийн газрын 2008 оны 134 дүгээр тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай төрийн өөрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулж ажиллах тухай албан бичиг хүргүүлэх, түрээсийн орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

2.УНТЭ-ийн эзэмшил газрын кадастрын зураг дээрх 27-30 цэг буюу эмнэлгийн тусамж үйлчилгээ, суралцагч оюутан, дагалдан эмчийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан 2016 онд “Эмч хөгжлийн төв”-ийн 4-н давхар барилга барихаар төлөвлөсөн, урд хэсгийн газрыг “Элит”-СӨХ хүүхдийн талбайгаар ашиглахаар хашаа барих, өөрсдийн эзэмшилд авах асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлжээ.

Иймд газар эзэмшигч байгууллагын хувьд байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, төрийн өмчийн эд хөрөнгө болох газар эзэмших эрхийг байгууллагын үндсэн үйл ажиллагаад ашиглах тул шилжүүлэх боломжгүй бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр үндсэн хөрөнгө данснаас хасдаг болохыг мэдэгдсэн албан бичгийг Нийслэлийн газрын алба болон “Элит”-СӨХ-д хүргүүлж ажиллах хэрэгтэй.

3.УНТЭ-ийн эзэмшил газрын байршлын кадастрын зураг дээрх 1-2, 2-4, 69-71 цэгийн газрыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн хашаа татаж, албан ёсны зөвшөөрөлгүй автомашины зогсоолоор ашиглаж байгаа бөгөөд уг газрын шилжүүлж авахаар маргаан үүссэн байна. Уг газрын ашиглалтыг төлбөрийг ШШҮХ огт төлж байгаагүй бөгөөд УНТЭ нь кадастрын зурагт заагдсан 25645 м.кв талбайд ногдох газрын төлбөрөө жил бүр төлж байна. Үүнд: 2018 онд 2,256,760 төгрөг, 2019 онд газрын төлбөр нэмэгдэж 5,385,450 төгрөг, 2020-2021 онд 5,385,450 мянган төгрөгийг төлжээ.

Мөн уг газрын доор тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дулааны болон хэрэгцээний цэвэр усны шугам байрладаг юм байна.

4.Эмнэлгийн зүүн урд хэсэгт байрлалтай 450 м.кв талбай бүхий газрыг Нийслэлийн засаг даргын 2005 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 243 тоот захирамжаар хасалт хийх шийдвэр гарсан хэдий ч 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Нийслэлийн засаг даргын 474 тоот захирамжаар Мөргөл уул ХХК-д эзэмшүүлэхээр гарсан шийдвэр гарсан байна. Уг хасагдсан газарт 2011 онд барилгын суурь цутгаж одоог хүртэл ашиглалтгүй балгас болж хог хаягдал дүүрсэн, эмнэлгийн орчинд сөргөөр нөлөөлөх аливаа эрсдэл үүсэх нөхцөл байдал үүссэн байгаа тул нийслэлийн газрын албанд дахин хүсэлт хүргүүлж шуурхай арга хэмжээ авах;

Түрээсийн талаар илэрсэн зөрчил, дутагдал:

1.Тус эмнэлгийн түрээсийн байр талбайтай танилцахад 3 АТМ болон 2 гэрэгэ киоскийн байр талбайг түрээслүүлэх түрээсийн гэрээгүй ажилласан зөрчил, дутагдал илэрлээ.

Нэр	Байршил	Сарын төлбөр	Түрээсийн төлбөр төлбөл зохих	
			хугацаа	дүн
Хас банк АТМ	С блок-Амбулаторийн хэсгийн 1 давхарт байрлах	49.50	15	742.50
Голомт банк АТМ	С блок-Амбулаторийн хэсгийн 1 давхарт байрлах	49.50	15	742.50
Төрийн банк АТМ	С блок-Амбулаторийн хэсгийн 1 давхарт байрлах	49.50	12	594.00
Түрээсийн төлбөрийн дүн				2,079.00
Улсын төсөвт төвлөрүүлэх дүн				831.60

Хас банк болон Голомт банкны АТМ байрлах талбайд 2020-2021 онд, Төрийн банкны АТМ байрлах талбайд 2021 онд түрээсийн гэрээ байгуулж ажиллаагүй бөгөөд төвлөрүүлбэл зохих 2.1 сая төгрөгийн орлогын 40% болох 831.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

2.Мөн амбулаторын 1 давхарт байрлалтай Гэрэгэ 2 ширхэг киоск байрлуулсан талбайг түрээслүүлэгчтэй харилцан тохирч түрээсийн төлбөрийг тогтоон гэрээ байгуулж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах нь зүйтэй.

3.Мөн тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Медвик эмнэлэгт ашиглагдаж байгаа диализын аппаратыг түрээсийн гэрээгүй ашиглуулж байна.

Тухайлбал тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Токушукэй группийн хандив тусламж болон улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон 656.0 сая төгрөгийн балансын үнэтэй 11 ширхэг диализын аппарат болон дагалдах бусад хөрөнгийг диализын чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх болсонтой холбогдуулан хувийн эмнэлэг болон цар тахалтай холбоотойгоор төрийн өмчийн эмнэлэгт тус тус ашиглаж байна.

Нийт 8 ширхэг аппаратыг бусад холбогдох тоног төхөөрөмжийн хамт тус эмнэлэгт байрлаж үйл ажиллагаа эрхэлж байгаа "Их шүүдэргэнэ импорт" ХХК-ийн Медвик эмнэлэг, 1 ширхэг аппаратыг Цэргийн төв /госпитал/ эмнэлэгт ашиглаж байгаа бөгөөд 2 ширхэг нь эвдэрсэн байдалтай байна. Цэргийн төв эмнэлэгтэй төрийн өмчийг ашиглуулсан гэрээ хэлцэл байхгүй байна. Мөн "Их шүүдэргэнэ импорт" ХХК-ийн Медвик эмнэлэг нь диализийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд талбайн түрээсийн гэрээ байгуулан тухай бүр төвлөрүүлэн ажиллаж байгаа хэдий ч тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8 ш ширхэг аппаратыг засаж сэргээн гэрээгүй ашиглаж байна.

Нийт Усны насос 3 ширхэг, Усны төхөөрөмж 1 ширхэг, Диализийн аппаратны ус цэвэршүүлэгч 1 ширхэг, Диализийн аппарат 10 ширхэг аппаратуудыг 2021 оны 02 сарын 04-ны өдөр тус эмнэлэгт хүлээлгэн өгсөн байна. Тус диализийн аппаратууд 20.0 мянган цаг ажилах ёстой боловч дунджаар нийтдээ 32.0 мянган цаг ажилласан, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө юм. Диализын аппаратын ашиглалтын төсөөллийг харуулбал:

Хөрөнгийн нэр	Аппара- тын тоо	Өдөрт орох хүний тоо	7 хоногт ажиллах өдөр	Сард ажилл ах тоо	Нэгж үнэ	Нийт ажлын хоног /2021.02.04- 11.30/	Нийт үйлчилгээ үзүүлсэн тоо
Гемодиализ аппарат	8	3	6	576	125,000	211	5,064

Энэ хугацаанд дунджаар 5 мянга гаруй өвчтөнд гемодиализийн үйлчилгээ үзүүлсэн төсөөллийг гаргаж харуулсан болно.

Диализын аппаратыг түрээслэх түрээсийн төлбөрийг түрээслэгчтэй харилцан тохиролцон тогтоож, 2022 онд төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулан ажиллах, түрээсийн нийт орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ТАВ. САНАЛ ДҮГНЭЛТ ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь мэдлэг, чадвар, хандлагаараа олон улсын жишигт нийцсэн, бүтээн байгуулалтын салбарын мэргэжилтэй ажилтанг бэлтгэх эрхэм зорилго тавин амжилттай ажиллаж байна.

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, шалгалтын ажлын хэсгийн гишүүд түрээслэгчидтэй нэг бүрчлэн уулзаж түрээсийн төлбөрийн үлдэгдэл тооцоог хийх, байр талбайд урсгал засвар хийж төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах талаар шаардлага тавьж ажилласны дүнд **94.9 сая** төгрөгийн түрээсийн орлого тус эмнэлэгт нэмж төвлөрүүлж түрээсийн нийт түрээсийн орлогын 40% хувь болох **141.4 сая** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, газрын маргаантай асуудал болон бүртгэлгүй нийтийн эзэмшлийн хөрөнгийг бүртгэлд тусгах талаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлж ажиллаа.

Төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, захиран зарцуулалтын байдалтай газар дээр нь танилцаж, хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналт, ашиглалт, үр ашиг “Төрийн өмч эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн шалгалтаар **143.1 сая** төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн тул зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй.

Шалгалтын дүнгээр хэрэгжүүлэх арга хэмжээ болон дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалын дагуу /7-р хавсралт/ барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа, их засварын зардлыг капиталжуулах, элэгдлийг тооцох, санхүүгийн тайлан бүртгэлд тусгах дүрэм журам, зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг баримталж ажиллах;

3.Тухайн жилд бий болсон хөрөнгийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу хүлээж авч, тухай бүр байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх арга хэмжээ авч байх;

4.Эвдэрсэн ч засаж ашиглах боломжтой тоног төхөөрөмжийг засварын зардлын асуудлыг шийдвэрлүүлж хэвийн үйл ажиллагаанд оруулах арга хэмжээ авах;

5.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмших эрхийн маргаантай асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авсан байх;

6.Банкны АТМ, Гэрэгэ киоскын байр талбай болон диализын аппаратыг түрээслүүлэх гэрээ байгуулж хөрөнгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх талаар

анхаарч ажиллах;

7.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажлыг идэвхжүүлэх, хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу зохион байгуулж тайлагнах;

8.Барилгын хувийн хэргийг шинэчлэх, баяжуулах;

9.Хөрөнгийн нэршлийг оновчтой, монгол хэлээр системтэй болгож сайжруулах, хөрөнгийг баркоджуулах ажлыг хийж дуусгах;

10.Агуулахад байгаа хөрөнгүүдийн байршил, /тавцангаар/ -аар нь картжуулж эмх цэгцтэй болгох;

11.Түрээсийн гэрээнд түрээсэлсэн эд хөрөнгийн фото зураг, түрээсийн барьцаа төлсөн баримт, тооцоо нийлсэн баримт, түрээслэгч иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, гэрээ дүгнэсэн тэмдэглэл зэргийг түрээсийн гэрээний архивын нэгжид хавсаргаж байх;

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөн туслах, байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

Хянасан:

Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийндарга, СХШ-ын Улсын ахлах байцаагч

Ц.Түвшинзаяа

Тайлан боловсруулсан:

Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, СХШ-ын Улсын ахлах байцаагч

Э.Ганчимэг

Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, СХШ-ын Улсын ахлах байцаагч

Ө.Батбаатар

Тайланг хүлээн зөвшөөрсөн:

Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Хишигжаргал

Ерөнхий нягтлан бодогч

Б.Банзрагч